



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2019. 10-14 № 23

Асуулга тавих тухай

Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр Улаанбаатар-Дарханы чиглэлд нэмэлт хоёр эгнээ бүхий авто зам барих төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулагдан 2019 оны 11 дүгээр сард ажлаа дуусгахаар шийдвэрлэсэн билээ. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын ажил нь Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр, “Бүс ба зам болон БНХАУ-Монгол Улс-ОХУ-ын эдийн засгийн коридор” байгуулах зорилтын хүрээнд эдийн засаг, худалдааны онцгой ач холбогдолтойгоос гадна иргэдийн амьдрал, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд ихээхэн нөлөө үзүүлдэг объект юм.

Зам барих ажил одоогоор гэрээнд заасан хугацаандаа дуусахааргүй, үүний улмаас олон иргэн эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирч байна. Холбогдох байгууллагаас авсан мэдээллээр Улаанбаатар-Дарханы чиглэлийн авто замд 2019 оны 06 дугаар сарын 17-ноос 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 104 осол гарч, 12 хүн нас барж, 43 хүн бэртэж, гэмтсэн байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтуудыг үндэслэн Танд Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын ажилтай холбоотойгоор дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Хүйтний улирал эхэлж, цас орж, халтиргаа гулгаа үүсэхээс өмнө замын ажлыг гэрээнд заасан хугацаанд дуусгаж, ашиглалтад оруулах боломжтой эсэх талаар;

2. Зам барих ажил удааширч байгаагийн шалтгаан юу болох, ажил гүйцэтгэж байгаа компаниудын үйл ажиллагаанд тавьж байгаа хяналт хангалттай байгаа эсэх талаар;


3. Зам барих ажлын санхүүжилт хугацаандаа хийгдэж байгаа эсэх болон туслан гүйцэтгэгч монгол аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэх талаар;

4. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замд гарах осол, зөрчлийг бууруулах талаар ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа, цаашид хийхээр төлөвлөж байгаа ажлын талаар;

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан хугацаанд асуулгын хариуг бичгээр ирүүлж, улмаар чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Н.ОЮУНДАРЬ

0000000106